

**Mongolian language for foreigners – Week 7**  
**Lecture №7**

**Сэдэв: Монголчуудын өнгөний бэлгэдэл**  
**Topic: Meanings of symbols**

**Сонсох, ярих, унших, бичих чадварыг дээшлүүлэх**  
**listening, speaking, reading, writing**

**Mongolian National University Arts And Culture**  
**Professor, Basbish.S**

## Хичээлийн агуулга - Lecture content

---

1. Өмнөх хичээлийн бататгал- Reviewing pervious learning
2. Монголчуудын өнгөний бэлгэдэл – Meanings of symbols
3. Дасгал ажлууд- Exercises
4. Шинэ үг хэллэгүүд- New words
5. Гэрийн даалгавар - Homework

Өмнөх хичээлийн бататгал буюу гэрийн даалгавар  
Reviewing pervious learning and homework

Мэдлэг шалгах тест - Test

1. Европ тивд анх .....онд Германы Иоганн Гүттенберг гэдэг хүн Библийн судрыг латин хэлээр хэвлэжээ.

- а. 1445                      б. 1450                      в. 1540                      г. 1545

2. 1311 онд 330 гаруй нүүр “Бодичаримаватарагийн тайлбар” хэмээх номыг 1000 ширхэг .....  
.....ХЭВЛЭЖЭЭ.

- а. төмөр бараар                       б. модон бараар                      в. зэс бараар                      г. чулуун бараар

3. Хамгийн эртний монгол бичигтэй хөшөө бол 1225 онд босгосон “.....” юм.

- а. Тоньюкукийн хөшөө                      б. Билгэ хааны хөшөө                      в. Культегиний хөшөө                       г. Чингисийн чулуу

4. Хуудсуудыг нь үдээгүй, салангид хэвлэсэн эсвэл бичсэн номыг .....НОМ ГЭНЭ.

- а. Нугалбар                      б. Хуйлмал                       в. сударчилсан                      г. дэвтэрлэсэн

5. Номын хуудаснуудын зүүн гар талын ирмэгүүдийг нааж үдсэн номыг .....НОМ ГЭНЭ.

- а. Нугалбар                      б. Хуйлмал                      в. сударчилсан                       г. дэвтэрлэсэн

Өмнөх хичээлийн бататгал буюу гэрийн даалгавар  
Reviewing pervious learning and homework

Мэдлэг шалгах тест - Test

6. Бичвэрээ урт, нарийн цаасан дээр хэвлэж эсвэл бичээд, нугалж эвхсэнийг .....ном гэдэг.

- а. Нугалбар                      б. Хуйлмал                      в. сударчилсан                      г. дэвтэрлэсэн

7. Монголчууд цааснаас гадна эрдэнээр ном судраа хэвлэж бүтээдэг байсан бөгөөд “.....” судрыг цэвэр мөнгөн цаасан дээр алтаар бичсэн.

- а. Сандуйн жүд                      б. Алтангэрэл                      в. Монголын нууц товчоо                      г. Эрдэнийн товч

8. Монголын нууц товчоо нь .....бүлэгтэй бөгөөд эхний .....бүлэг нь Чингис хааны тухай, дараагийн .....бүлэг нь Өгөөдэй хааны тухай өгүүлдэг.

- а. 12,10,2                      б. 18,10,8                      в. 13,9,4                      г. 12, 8, 4

9. Монгол үндэстний хувьд түүх, уран зохиол, хэл шинжлэлийн хосгүй үнэт дурсгал бол “.....” юм.

- а. Зүрхэн тольт                      б. Мэргэд гарахын орон                       в. Монголын нууц товчоо                      г. Эрдэнийн сан Субашид

10. МНТ-ны талаар .....гаруй судалгааны бүтээл нийтлэгдсэн.

- а. 500                       б. 1000                      в. 100                      г. 1500

*Дасгал 1. Асуултыг уншаарай. - Read the questions.*

1. Ямар ямар өнгө байдаг вэ?
2. Чи ямар өнгөнд дуртай вэ? Яагаад?
3. Өнгө ямар нэг зүйлийг бэлгэддэг үү?

(Мөнхцэцэг, Г., Орхон, Б, 2021, хууд. 134)



Ганзул. (2016, October 15). Өнгөний сэтгэл зүй  
[Photograph]. setgelmn.wordpress.com.  
<https://11nq.com/UdwcW>

МОНГОЛЧУУДЫН ӨНГӨНИЙ БЭЛГЭДЭЛ  
Meanings of symbols

---

*Дасгал 2. Сонсоод, эхийн орхигдсон үгсийг нөхөж бичнэ үү.*

*Exercise 2. Listen and fill the missing words*

*Нөхөх үгс: Choose from following words: эд зүйлийн, үнэнч, газар шороо, газар дэлхий, хадгийг, нарны, тэнгэрийн, сүүг, сүр хүчний, гал голомтны*

### Монголчуудын өнгөний бэлгэдэл

Монголчууд өнгө бүрийг бэлгэдэлт утгатай гэж үздэг бөгөөд 1) \_\_\_\_\_  
\_\_\_\_\_ өнгийг сонгохын тулд бэлгэдлийг нь харгалздаг. Монголчуудын өнгөний бэлгэдэл өргөн утга агуулгыг илэрхийлдэг. (Мөнхцэцэг, Г., Орхон, Б, 2021, хууд. 134)

МОНГОЛЧУУДЫН ӨНГӨНИЙ БЭЛГЭДЭЛ  
Meanings of symbols

---

*Дасгал 2. Сонсоод, эхийн орхигдсон үгсийг нөхөж бичнэ үү.*

*Exercise 2. Listen and fill the missing words*

*Нөхөх үгс: Choose from following words: эд зүйлийн, үнэнч, газар шороо, газар дэлхий, хадгийг, нарны, тэнгэрийн, сүүг, сүр хүчний, гал голомтны*

**Цагаан:** Монголчууд эхийн цагаан 2) \_\_\_\_\_ хамгийн ариун нандин зүйл гэж бэлгэшээн дээдэлдэг бөгөөд цагаан өнгөөр сүүг төлөөлүүлж үздэг. Тийм учраас өнгө өнгөний дундаас цагаан өнгийг ихэд эрхэмлэдэг.

Цагаан өнгөөр ариун нандин, ариун журамт сэтгэл, хиргүй тунгалаг гэх мэт бүхий л сайн сайхан зүйлийг бэлгэддэг. Мөн төрийн сүлдний их цагаан тугийг цагаан адууны хялгасаар хийдэг. Цагаан 3) \_\_\_\_\_ хамгийн эрхэм дээд, хүндэтгэдэг хүндээ өргөн барина. (Мөнхцэцэг, Г., Орхон, Б, 2021, хууд. 134)

# МОНГОЛЧУУДЫН ӨНГӨНИЙ БЭЛГЭДЭЛ

## Meanings of symbols



Таван өнгийн хадаг юуг бэлгэддэг вэ? [Photograph]. (2016, February 7).  
<https://www.infomongol.mn/a/65935>



Цэнгэл, Б. (2018, February 12). Хадагтай золгох ёс [Photograph].  
<https://www.unen.mn/a/81328>

*Дасгал 2. Сонсоод, эхийн орхигдсон үгсийг нөхөж бичнэ үү.*

*Exercise 2. Listen and fill the missing words*

*Нөхөх үгс: Choose from following words: эд зүйлийн, үнэнч, газар шороо, газар дэлхий, хадгийг, нарны, тэнгэрийн, сүүг, сүр хүчний, гал голомтны*

**Хөх:** Хөх өнгийг мөнх хөх 4) \_\_\_\_\_ өнгө гэж бэлгэшээн дээдэлж, энэ өнгийг хүндлэлийн дээд гэж үздэг. Тийм ч учраас төрийн далбаанд мөнх хөх тэнгэрийг бэлгэдэн хөх өнгийг оруулсан. Хөх, цэнхэр өнгө нь мөн 5) \_\_\_\_\_ ёсыг илэрхийлдэг тул хөх, цэнхэр өнгийн хадгийг ихэвчлэн ах дүүсдээ барьж, мэнд мэдэн золгодог.

*Дасгал 2. Сонсоод, эхийн орхигдсон үгсийг нөхөж бичнэ үү.*

*Exercise 2. Listen and fill the missing words*

*Нөхөх үгс: Choose from following words: эд зүйлийн, үнэнч, газар шороо, газар дэлхий, хадгийг, нарны, тэнгэрийн, сүүг, сүр хүчний, гал голомтны*

**Улаан:** Улаан өнгийг 6) \_\_\_\_\_ өнгө, өөдлөн дэвжих, ялан дийлэхийн бэлгэ тэмдэг гэж бэлгэшээдэг. Улаан хадгийг бурхны шашны таван махбодын тусгай үйлд хэрэглэдэг бөгөөд хүмүүст барьж золгодоггүй.

МОНГОЛЧУУДЫН ӨНГӨНИЙ БЭЛГЭДЭЛ  
Meanings of symbols

---

*Дасгал 2. Сонсоод, эхийн орхигдсон үгсийг нөхөж бичнэ үү.*

*Exercise 2. Listen and fill the missing words*

*Нөхөх үгс: Choose from following words: эд зүйлийн, үнэнч, газар шороо, газар дэлхий, хадгийг, нарны, тэнгэрийн, сүүг, сүр хүчний, гал голомтны*

**Ногоон:** Ногоон өнгө нь 7) \_\_\_\_\_, үржил хөгжлийг бэлгэдсэн өнгө бөгөөд санаа сэтгэлийн амар амгалан байдал, хүнд итгэл төрүүлдэг байна. (Мөнхцэцэг, Г., Орхон, Б, 2021, хууд. 134)

Ногоон өнгөний бэлгэдлийн уг язгуур гарвал нь байгаль, ертөнцийн эх үзэгдэл /өвс ногоо/ цэцэг навчны урган төлжих, цэцэглэн дэлгэрэх үйл, цаг хугацаа, нөхцөл байдалтай шууд холбоотой. Байгаль ертөнцийн юм үзэгдлийг мэдрэхгүйн туршлагаар танин мэдсэнээ уран сайхнаар нэвтрүүлсэн илэрхийлэл болох “ертөнцийн гурван ногоон” гэдгийг олон янзын хувилбараар өгүүлэх боловч энд ихэнхдээ мөнх ногоон ургамлууд /арц, хуш, зээргэнэ/ эсвэл ургамлын ерөнхий болон тусгай зүйлүүд /дэлхийн ногоо, усны замаг, хадны хөгц/ хааяа бие эрхтний болон чулуулгийн зүйл /цөс, номин/ оролцож дурдагдана.

(Дулам.С, 2011, хууд. 27)

*Дасгал 2. Сонсоод, эхийн орхигдсон үгсийг нөхөж бичнэ үү.*

*Exercise 2. Listen and fill the missing words*

*Нөхөх үгс: Choose from following words: эд зүйлийн, үнэнч, газар шороо, газар дэлхий, хадгийг, нарны, тэнгэрийн, сүүг, сүр хүчний, гал голомтны*

**Шар:** Шар өнгө бол амьдралыг тэтгэгч алтан шар 8) \_\_\_\_\_ өнгө юм. Монголчууд шар өнгийг мөн эрдэм оюуны өнгө гэж үздэг бөгөөд шар өнгийн хадгийг багшдаа барьдаг. Алтан шар өнгө нь оюуны гэрэл гэгээ, итгэл найдвар, аз жаргал, баяр баясгалан, баян тансаг, сүрлэг бадрангуй, сүр хүчийг харуулна. Улбар шар нь амар тайван, баяр баясгалан, хангалуун байдлын бэлгэдэл болно.

*Дасгал 2. Сонсоод, эхийн орхигдсон үгсийг нөхөж бичнэ үү.*

*Exercise 2. Listen and fill the missing words*

*Нөхөх үгс: Choose from following words: эд зүйлийн, үнэнч, газар шороо, газар дэлхий, хадгийг, нарны, тэнгэрийн, сүүг, сүр хүчний, гал голомтны*

**Хар:** Монголчууд хар өнгийг дийлдэж давагдашгүй 9) \_\_\_\_\_ бэлгэдэл хэмээн үздэг. Тийм учраас хар өнгө нь дэг журам, эв нэгдэл, эрх мэдэл, хүч чадал, хүсэл зориг, эрч хүчийг бэлгэддэг.

*Дасгал 2. Сонсоод, эхийн орхигдсон үгсийг нөхөж бичнэ үү.*

*Exercise 2. Listen and fill the missing words*

*Нөхөх үгс: Choose from following words: эд зүйлийн, үнэнч, газар шороо, газар дэлхий, хадгийг, нарны, тэнгэрийн, сүүг, сүр хүчний, гал голомтны*

**Бор:** 10) \_\_\_\_\_, таван махбодийг илэрхийлэх бөгөөд төр тогтвортой, хариуцлагатай байхын бэлгэдэл болдог.

*Дасгал 3. Ертөнцийн гурвыг уншаад цээжлээрэй.*


*Exercise 3. Memorize The triads of the Universe*

**Ертөнцийн гурван цагаан**

Өсөхөд шүд нэг цагаан

Өтлөхөд үс нэг цагаан

Үхэхэд яс нэг цагаан



Байгаль, ертөнцийн юмс үзэгдлийн дотроос шинж, төлвөөрөө нийтлэг гурван зүйлийг онцлон гурван мөрөөр илэрхийлсэн уран шүлэглэлийг ертөнцийн гурав гэнэ.

# МОНГОЛЧУУДЫН ӨНГӨНИЙ БЭЛГЭДЭЛ

## Meanings of symbols

Монгол ертөнцийн гуравт /хөх юмуу цэнхэрт/ заавал багтаж ордог нь тэнгэр, ус, утаа, галын дөл, холын уул зэрэг болно.

Уудам дэлхийн тэнгэр нэг хөх

Унтрах галын дөл нэг хөх

Урсах голын ус нэг хөх (Хорлоо.П, 1966, хууд. 117)

Уудам огторгуй нэг цэнхэр

Урсах ус нэг цэнхэр

Уугих утаа нэг цэнхэр

Холоос харагдаж байгаа уул нэг цэнхэр

Хонхорт харагдаж байгаа ус нэг цэнхэр

Хорвоод байгаа тэнгэр нэг цэнхэр (Дулам.С, 2011, хууд. 26)

Энэхүү ертөнцийн гурван хөх, цэнхрүүд нь голдуу байгалийн юмс үзэгдлийн өнгө байгаа учраас бэлгэдлийн утга гэж үгүй.



Тэшигийн буган хөшөө - Монголын сайхан орон [Photograph]. (2015, November 29).

<https://www.assa.mn/a/34334>

# МОНГОЛЧУУДЫН ӨНГӨНИЙ БЭЛГЭДЭЛ

## Meanings of symbols

Ертөнцийн гурван улаан

Жавартай тэнгэрийн хаяа нэг улаан

Жаргалтай хатны хацар нэг улаан

Жалганд ургасан сухай нэг улаан

(Ариунжаргал.Г, 2008, хууд. 55)



Долгор, Д. (2022, July 1). Тэнгэрийн улбар туяа [Photograph].  
<https://www.inews.mn/a/27568>



Сухай. (n.d.).  
<https://ubtgarden.mn/product/suhai/>



Unknown. (2017, August 9). БӨРТЭ ҮЖИН ХАТАН. my.noodletools.com.  
<http://nuutstovchoo.blogspot.com/2017/08/blog-post.html>

# МОНГОЛЧУУДЫН ӨНГӨНИЙ БЭЛГЭДЭЛ

## Meanings of symbols

### Ертөнцийн гурван ногоон

Усанд замаг нэг ногоон

Хаданд хөгц нэг ногоон

Дэлхийд ногоо нэг ногоон

Хад нь хар ч хаг нь ногоон

Элэг нь хар ч цөс нь ногоон

Ус нь хар ч замаг нь ногоон

Тагт ургасан арц нэг ногоон

Тайгад ургасан хуш нэг ногоон

Талд ургасан зээргэнэ нэг ногоон (Дулам.С, 2011, хууд. 27)



tengeruhaan. (2019, May 13). Хадны хаг [Photograph].  
<https://encr.pw/UeHpB>



tengeruhaan. (2019, May 14). Арц [Photograph].  
<https://encr.pw/sw821>



Drew Avery. (2009, April 24). Зээргэнэ [Photograph]. Wikipedia.

[https://mn.wikipedia.org/w/index.php?title=%D0%9C%D0%BE%D1%80%D0%B8%D0%BD\\_%D0%B7%D1%8D%D1%8D%D1%80%D0%B3%D1%8D%D0%BD%D1%8D&oldid=507862.#/media/%D0%A4%D0%B0%D0%B9%D0%BB:Ephedra\\_equisetina\\_2.jpg](https://mn.wikipedia.org/w/index.php?title=%D0%9C%D0%BE%D1%80%D0%B8%D0%BD_%D0%B7%D1%8D%D1%8D%D1%80%D0%B3%D1%8D%D0%BD%D1%8D&oldid=507862.#/media/%D0%A4%D0%B0%D0%B9%D0%BB:Ephedra_equisetina_2.jpg)

**Ертөнцийн гурван хар**

Айраг цагаанаас гарч байвч архи нэг хар

Арчиж зүлгэж байвч тогоо нэг хар

Алт мөнгөөр чимж байвч үс нэг хар

(Ариунжаргал.Г, 2008, хууд. 70)



Админ. (2021, February 19). Архи нэрэх [Photograph].  
<https://mongolix.mn/read/post/1976348>

МОНГОЛЧУУДЫН ӨНГӨНИЙ БЭЛГЭДЭЛ  
Meanings of symbols

---

***Дасгал 4. Дараах асуултын дагуу ярилцаж, ойлголтоо шалгаарай.  
Exercise 4. Discuss about following questions and review your understanding***

1. Монголчууд эд зүйлийн өнгийг сонгохдоо юуг харгалздаг вэ?

.....

2. Монголчууд яагаад цагаан өнгийг хамгаас эрхэмлэн дээдэлдэг вэ?

.....

3. Хөх өнгө юуг бэлгэддэг вэ?

.....

4. Улаан өнгө юуг бэлгэддэг вэ?

.....

***Дасгал 4. Дараах асуултын дагуу ярилцаж, ойлголтоо шалгаарай.  
Exercise 4. Discuss about following questions and review your understanding***

1. Ногоон өнгө юуг бэлгэддэг вэ?

.....

2. Шар өнгө юуг бэлгэддэг вэ?

.....

3. Хар өнгө юуг бэлгэддэг вэ?

.....

4. Бор өнгө юуг бэлгэддэг вэ?

.....

МОНГОЛЧУУДЫН ӨНГӨНИЙ БЭЛГЭДЭЛ  
Meanings of symbols

---

**Дасгал 5. Өгөгдсөн үгсийг тайлбартай нь тохируулна уу.**  
**Exercise 5. Match following words to its explanation.**

- |                |                                    |
|----------------|------------------------------------|
| 1. Өнгө орох   | а) үзэмж сайтай болох              |
| 2. Өнгөө алдах | б) дээлэнд гадар оёх, солих        |
| 3. Өнгө татах  | в) таарах зохицох, сайхан харагдах |
| 4. Өнгө хорших | г) зүс царай, үзэмжээ сайжруулах   |
| 5. Өнгө засах  | д) тухайн цаг үеийн нөхцөл байдал  |
| 6. Өнгө сайтай | е) үзэмж сайтай                    |
| 7. Цагийн өнгө | ё) зүс царай доройтох, муу болох   |

МОНГОЛЧУУДЫН ӨНГӨНИЙ БЭЛГЭДЭЛ  
Meanings of symbols

---

*Дасгал 6. Дээрх үгсийг ашиглан өгүүлбэрийг гүйцээж бичнэ үү.  
Exercise 6. Complete the sentence using above words*

1. Цагаан хувцсыг лимонтой усаар угаавал сайн ..... –дог.
2. .... –сан мөнгөн эдлэлийг шүдний оогоор угаадаг.
3. Чиний улаан туфль цагаан цүнх хоёр сайхан ..... –ж байна.
4. .... бүхэн чанартай байдаггүй.
5. Хэдэн өдөр бороо орсны ачаар байгаль дэлхий ..... –чээ.
6. Манай нутгийн намар ..... хэчнээн сайхан гэж санана.
7. Эмээ миний хурган дээлэнд шинэ ..... –ж өглөө.

МОНГОЛЧУУДЫН ӨНГӨНИЙ БЭЛГЭДЭЛ  
Meanings of symbols

---

*Дасгал 7. Тохирох нөхцөлүүдийг ашиглан өгүүлбэрийг гүйцээж бичнэ үү.  
Exercise 7. Complete the sentence using above words*

*Нөхцөлүүд: (-аарай<sup>4</sup>, -аасай<sup>4</sup>, -аач<sup>4</sup>, -уузай<sup>2</sup>, -г, -я<sup>3</sup>, битгий-аарай<sup>4</sup>)*

1. Зуны цагт цагаан идээ сайн ид .....
2. Энэ цагаан луувангаас ид ..... Муудчихсан шүү!
3. Цэнхэр үзгээр бич..... яагаад улаанаар бичээд байгаа юм бэ?
4. Би чамтай хамт Улаанбаатар луу яв.....
5. Дахиад улаан лооль ..... хий.....
6. Бат өнөөдөр хүрэн дээлээ өмс..... Бүгд хүрэн дээл өмсөхөөр болсон.
7. Аав надад шаргал цув авч өг.....

МОНГОЛЧУУДЫН ӨНГӨНИЙ БЭЛГЭДЭЛ  
Meanings of symbols

---

Шинэ үг хэллэгүүдийг цээжилж, утгыг ойлгоорой.  
Memorize the new vocabularies and understand the meaning

1. Ариун нандин- sacred
2. Ариун журамт сэтгэл – pure mind
3. Бурхны шашны таван махбод – the five elements of Buddhism (fire, earth, metal, water, wood)
4. Бэлгэшээх – to consider as a good omen
5. Дийлдэж давагдашгүй - supernatural
6. Дэг журам - principle
7. Дээдлэх – to revere
8. Мөнх хөх тэнгэр – eternal blue heaven (eternal blue sky)
9. Өөдлөн дэвжих – to thrive, to flourish
10. Сүрлэг бадрангуй - majestic
11. Тогтвортой – stable, steady

МОНГОЛЧУУДЫН ӨНГӨНИЙ БЭЛГЭДЭЛ  
Meanings of symbols

---

Шинэ үг хэллэгүүдийг цээжилж, утгыг ойлгоорой.  
Memorize the new vocabularies and understand the meaning

1. Үржил хөгжил - multiplication
2. Хадаг – ceremonial scarf
3. Хангалуун – replete, rich
4. Харгалзах – to take into account
5. Хариуцлагатай - responsible
6. Хиргүй тунгалаг – pure, sacred
7. Хүсэл зориг - aspiration
8. Хүч чадал - strength
9. Эв нэгдэл- unity
10. Эрч хүч - exuberance
11. Ялан дийлэх – to triumph (over), to defeat

МОНГОЛЧУУДЫН ӨНГӨНИЙ БЭЛГЭДЭЛ  
Meanings of symbols

Гэрийн даалгавар 1   
Homework 1

Мэдлэг шалгах тест - Test

1. Монголчууд өнгө бүрийг бэлгэдэлт утгатай гэж үздэг бөгөөд ..... өнгийг сонгохын тулд бэлгэдлийг нь харгалздаг.

А. Эд зүйлийн                      б. Хоол хүнсний                      в. Байгаль дэлхийн                      г. Цаг агаарын

2. Монголчууд эхийн цагаан сүүг хамгийн ..... зүйл гэж бэлгэшээн дээдэлдэг бөгөөд цагаан өнгөөр сүүг төлөөлүүлэн, өнгө, өнгийн дундаас хамгийн ихээр эрхэмлэн дээдэлдэг.

А. амттай, шимтэй                      б. Ариун нандин                      в. Тансаг сайхан                      г. Өтгөн тослог

3. Хөх өнгийг мөнх хөх ..... өнгө гэж бэлгэшээн дээдэлж, энэ өнгийг хүндлэлийн дээд гэж үздэг.

А. Далайн                      б. Голын                      в. Талын                      г. Тэнгэрийн

4. Хөх цэнхэр өнгө нь мөн ..... ёсыг илэрхийлдэг тул хөх, цэнхэр өнгийн хадгийг ихэвчлэн ах дүүсдээ барьж, мэнд мэдэн золгодог.

А. Эелдэг                      б. Үнэнч                      в. Найрсаг                      г. Зочломтгой

5. Улаан өнгийг ..... өнгө, өөдлөн дэвжих, ялан дийлэхийн бэлгэ тэмдэг гэж бэлгэшээдэг.

А. Гал голомтны                      б. Бурхан тахилын                      в. Хоол хүнсний                      г. Чимэг зүүлтний

МОНГОЛЧУУДЫН ӨНГӨНИЙ БЭЛГЭДЭЛ  
Meanings of symbols

Гэрийн даалгавар 1  
Homework 1



Мэдлэг шалгах тест - Test

6. Ногоон өнгө нь ....., үржил хөгжлийг бэлгэдсэн өнгө бөгөөд санаа сэтгэлийн амар амгалан байдлыг илтгэнэ.

А. Газар дэлхий                      б. Нар сар                      в. Гараг эрхэс                      г. Тэнгэр огторгуй

7. Ногоон хадгийг .....зан үйлд хэрэглэнэ.

А. Тайлга тахилгын                      б. Бурханд мөргөх                      в. Ахмадуудтай золгох                      г. Багш шавийн

8. Шар өнгө бол амьдралыг тэтгэгч алтан шар .....өнгө юм.

А. Цэцгийн                      б. Сарны                      в. Нарны                      г. Алтны

9. Монголчууд шар өнгийг мөн эрдэм оюуны өнгө гэж үздэг бөгөөд шар өнгийн хадгийг.....барьдаг.

А. Өвөөдөө                      б. эмээдээ                      в. даргадаа                      г. Багшдаа

10. Монголчууд хар өнгийг дийлдэж давагдашгүй .....бэлгэдэл хэмээн үздэг.

А. Оюун ухааны                      б. Хөгжиж цэцэглэхийн                      в. Муу санааны                      г. Сүр хүчний

МОНГОЛЧУУДЫН ӨНГӨНИЙ БЭЛГЭДЭЛ  
Meanings of symbols

---

Гэрийн даалгавар 2  
Homework 2



<https://thenounproject.com/icon/homework-3841940/>

- *Сэдэвт гарсан шинэ үг хэллэгүүдийг цээжлээрэй.  
Memorize vocabulary in the given topic*
- *Өөрийн орны өнгөний бэлгэдлийн талаар бичнэ үү.  
Write about the color symbols of your country*

## НОМ ЗҮЙ, АШИГЛАСАН МАТЕРИАЛ-REFERENCES

### НОМ ЗҮЙ

Ариунжаргал.Г. (2008). Монгол хэлний зөв бичих зүйн дүрэм дасгал. Улаанбаатар:

ТЗҮААЭГ-ийн харьяа хэвлэх үйлдвэр.

Дулам.С. (2011). Монгол бэлгэдэл зүй-II Өнгийн бэлгэдэл зүй, Зүг чигийн бэлгэдэл зүй. Улаанбаатар:

Битпресс.ХХК.

Мөнхцэцэг,Г.,Орхон,Б. (2021). Монгол орон судлал. Улаанбаатар: Линограф.

Хорлоо.П. (1966). Монгол ардын цэцэн зүйр үгүүд ба оньсогууд. Улаанбаатар: ШУАХ.

## НОМ ЗҮЙ, АШИГЛАСАН МАТЕРИАЛ-REFERENCES

Таван өнгийн хадаг юуг бэлгэддэг вэ? [Photograph]. (2016, February 7).

<https://www.infomongol.mn/a/65935>

Цэнгэл, Б. (2018, February 12). Хадагтай золгох ёс [Photograph].

<https://www.unen.mn/a/81328>

Ганзул. (2016, October 15). Өнгөний сэтгэл зүй [Photograph].

[setgelmn.wordpress.com](http://setgelmn.wordpress.com). <https://l1nq.com/UdwcW>

Тэшигийн буган хөшөө - Монголын сайхан орон [Photograph]. (2015,

November 29). <https://www.assa.mn/a/34334>

Долгор, Д. (2022, July 1). Тэнгэрийн улбар туяа [Photograph].

<https://www.inews.mn/a/27568>

Unknown. (2017, August 9). БӨРТЭ ҮЖИН ХАТАН. [my.noodletools.com](http://my.noodletools.com).

<http://nuutstovchoo.blogspot.com/2017/08/blog-post.html>

tengeruhaan. (2019, May 13). Хадны хаг [Photograph]. <https://encr.pw/UeHpB>

Drew Avery. (2009, April 24). Зээргэнэ [Photograph]. Wikipedia.

[https://mn.wikipedia.org/w/index.php?title=%D0%9C%D0%BE%D1%80%D0%B8%D0%BD\\_%D0%B7%D1%8D%D1%8D%D1%80%D0%B3%D1%8D%D0%BD%D1%8D&oldid=507862.#/media/%D0%A4%D0%B0%D0%B9%D0%BB:Ephedra\\_equisetina\\_2.jpg](https://mn.wikipedia.org/w/index.php?title=%D0%9C%D0%BE%D1%80%D0%B8%D0%BD_%D0%B7%D1%8D%D1%8D%D1%80%D0%B3%D1%8D%D0%BD%D1%8D&oldid=507862.#/media/%D0%A4%D0%B0%D0%B9%D0%BB:Ephedra_equisetina_2.jpg)

tengeruhaan. (2019, May 14). Арц [Photograph].

<https://encr.pw/sw821>

Админ. (2021, February 19). Архи нэрэх [Photograph].


<https://mongoliax.mn/read/post/1976348>

МОНГОЛЧУУДЫН ӨНГӨНИЙ БЭЛГЭДЭЛ  
Meanings of symbols

**Анхаарал хандуулсанд баярлалаа  
Дараагийн хичээл хүртэл баяртай!**



[https://www.flaticon.com/free-icon/teacher\\_1995413](https://www.flaticon.com/free-icon/teacher_1995413)



<https://thenounproject.com/icon/lecture-1525984/>